



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 1/22

Хөхбүрд

Г Ёс зүйн салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 6.2 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төрийн байгууллагуудад ажиллаж байгаа албан хаагчдын ёс зүй, харьцаа хандлага зэргийг сайжруулах, тэдэнд зөвлөгөө өгөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллах ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс зүйн зөвлөлийн дарга: Н.Март (Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер)

Гишүүд: Д.Отгонцэцэг (Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Б.Пүрэвдорж (Ерөнхий боловсролын сургуулийн Насан туршийн боловсролын менежер)

Г.Бямбасүрэн (Эрүүл мэндийн төвийн бичиг хэргийн ажилтан)

Б.Болортуяа (Соёлын төвийн Номын санч, бичиг хэргийн ажилтан)

О.Мөнхцэцэг (Цэцэрлэгийн туслах багш)

Нарийн бичгийн дарга: П.Мөнхтогоо (Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

2.Дагаж мөрдөх дүрэм боловсруулж, баталуулж ажиллахыг Ёс зүйн зөвлөлийн дарга (Н.Март)-д үүрэг болгосугай.

3.Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчдад дүрмийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүдэд даалгасугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР

642201115